



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 7 сарын 23 өдөр

Дугаар В/406

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 71 дүгээр цэцэрлэгийн  
өргөтгөлийн барилга данснаас  
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 103 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/924 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн өргөтгөлийн хуучин барилгыг буулгаж шинээр өргөтгөл барихтай холбогдуулан Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-117/1136 тоот дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Хан-Уул дүүргийн 71 дүгээр цэцэрлэгийн балансад бүртгэлтэй хавсралтад заасан нийт 4,775,660.80 /дөрвөн сая долоон зуун далан таван мянга зургаан зуун жаран төгрөг наян мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 71 дүгээр цэцэрлэг /С.Эрдэнэчимэг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой хөрөнгийг худалдан борлуулахаар үнэлсэн 480.000.0 /дөрвөн зуун наян мянган/ төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050000965

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн  
№406 дугаар тушаалын хавсралт



### НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга	31	м2	62	4,775,660.80	4,775,660.80	994,929.34	3,780,731.46
Нийт дүн						4,775,660.80	994,929.34	3,780,731.46